



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/103

Дархан сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын хадлангийн талбай хуваарилах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	С.Амарболд	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Ш.Отгонжаргал	(Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	Г.Ганболд	(Газрын даамал)
	Н.Цэрэнжав	(1 дүгээр багийн Засаг дарга)
	А.Пунцагдорж	(3 дугаар багийн Засаг дарга)
	Ц.Ганбат	(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Ж.Оюунболд	(ИТХ-ын төлөөлөгч)

2. Хадлангийн талбай хуваарилах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг (С.Амарболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТБОЛД